

**2022 оны 8 сарын өргөдөл гомдол, шийдвэрлэлтийн байдал:** Erp.Ulaanbaatar.mn өргөдөл гомдлын программд 8 дугаар сарын байдлаар нийт 25 өргөдөл гомдол бүртгэгдсэн. Үүнээс иргэнээс 11 өргөдөл, албан хаагчаас 14 өргөдөл ирсэн. 100 хувь буюу 25 өргөдөл гомдлыг бүрэн шийдвэрлэсэн. Өргөдөл гомдлыг шийдвэрлэх явцад өдөрт нь багтаан хүлээн аваагүй 2 зөрчил илэрсэн. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй. Саналын шинжтэй өргөдөл гомдол ирээгүй.

**2022 оны 10 сарын байдлаар:** Erp.Ulaanbaatar.mn өргөдөл гомдлын программд 10 дугаар сарын байдлаар нийт 28 өргөдөл гомдол бүртгэгдсэн. Үүнээс иргэнээс 17 өргөдөл, албан хаагчаас 11 өргөдөл ирсэн. 67.85 хувь буюу 19 өргөдөл гомдлыг шийдвэрлэж, 32.15 хувь буюу 9 өргөдөл гомдол шийдвэрлэх шатандаа судлагдаж байна. Өргөдөл гомдлыг шийдвэрлэх явцад өдөрт нь хүлээн аваагүй зөрчил-1, явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил-1 тус тус илэрсэн.

**2022 оны 11 сарын байдлаар:** Erp.Ulaanbaatar.mn өргөдөл гомдлын программд 11 дүгээр сарын байдлаар нийт 24 өргөдөл гомдол бүртгэгдсэн. Үүнээс иргэнээс 11 өргөдөл, албан хаагчаас 13 өргөдөл ирсэн. 100 хувь буюу 24 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн. Өргөдөл гомдлыг шийдвэрлэх явцад явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил 2 илэрсэн. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй.

#### **2022 оны Хагас жилийн өргөдөл, гомдол, шийдвэрлэлтийн байдал:**

#### НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

Erp.Ulaanbaatar.mn өргөдөл гомдлын программд хагас жилийн байдлаар нийт 77 өргөдөл гомдол бүртгэгдсэн. Үүнээс иргэнээс 45 өргөдөл, албан хаагчаас 32 өргөдөл ирсэн. 93.5 хувь буюу 72 өргөдөл гомдлыг шийдвэрлэж, 6.5 хувь буюу 5 өргөдөл гомдол шийдвэрлэх шатандаа судлагдаж байна. Өргөдөл гомдлыг шийдвэрлэх явцад 2 зөрчил илэрсэн. Хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл гомдол байхгүй. Өргөдөл гомдлыг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулбал 36 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2022 оны өргөдөл гомдлыг 2021 онтой харьцуулбал:

